

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2026/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026-02-24 № 180
танай _____ ны № _____ Т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Ү.БЯМБАСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,434.5 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 1,119.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 65.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны байгууллагад хүргүүлж гүйцэтгэлээр Улсын төсвөөс 1,119.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 1,110.8 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65.0 сая төгрөгийн зарцуулах эрх авч 160.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст улсын төсөвт 107.8 сая төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 83 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/83 тоот тушаалаар нэмэлт дансанд төвлөрдөг хяналтын орлогоос зарцуулах эдийн засгийн зардлын ангиллыг зааж өгсөн боловч 0.66 сая төгрөгийн санхүүгийн программын төлбөр төлсөн нь тус тушаалын хавсралттай нийцэхгүй байна.

6326050181

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	123,360.61	95,911.46
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	664,981	710,834.58
	Нийт хөрөнгийн дүн	788,341.62	806,746
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	788,257.62	806,746
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	788,341.62	806,746
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,532,062	1,512,906
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,525,639	1,494,418
	Үйл ажиллагааны үр дүн	1,006,423	18,488.43
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,006,423	18,488.43
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
		0	0
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-218,165.28	788,257.62
	Тайлант оны үр дүн	0	18,488.43
	Эцсийн үлдэгдэл	788,257.62	806,746
Мөнгөн гүйлгээний тайлан			
		0	0
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,516,517	1,394,392
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,413,800	1,380,163
	Үйл ажиллагааны ЦМГ	102,717	14,229
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-102,717	-14,229
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,217,244	1,175,015
	Урсгал зардал	1,217,244	1,175,015
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	0	0
	Улсын төсвөөс санхүүжих	0	1,119,600
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Газрын харилцаа, барилгын салбарын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж, газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, барилга хот төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэн иргэдийн амьжиргааны түвшнийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй, шуурхай үзүүлэх эрхэм зорилготой төрийн байгууллага юм.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэн

Тус газар нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,434.5 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 1,119.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 65.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд

шатны байгууллагад хүргүүлж гүйцэтгэлээр Улсын төсвөөс 1,119.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 1,110.8 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65.0 сая төгрөгийн зарцуулах эрх авч 160.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст улсын төсөвт 107.8 сая төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлж ажилласан байна.

Тав. Аудитын гол асуудал

Тус газар нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,434.5 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 1,119.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 65.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны байгууллагад хүргүүлж гүйцэтгэлээр Улсын төсвөөс 1,119.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 1,110.8 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 65.0 сая төгрөгийн зарцуулах эрх авч 160.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст улсын төсөвт 107.8 сая төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлж ажилласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн оруулах, төсвийг зохистой удирдах

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,351,186.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,351,186.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчил нь 3,351,186.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь материаллаг бус зөрчил тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага бичигдээгүй

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой

Илрүүлэлт:

Шилэн дансны 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2. Санхүүгийн программтай холбоотой

Илрүүлэлт:

Барилга хот байгуулалтын сайдын 2022.04.11 83 дугаар тушаал, ГЗБГЗЗЕГД-гын 2024.03.18 А/83 тоот тушаалаар нэмэлт дансанд төвлөрдөг хяналтын орлогоос зарцуулах

эдийн засгийн зардлын ангиллыг зааж өгсөн боловч 660.0 мянга төгрөгийн санхүүгийн программын төлбөр төлсөн нь тус тушаалын хавсралттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Барилга хот байгуулалтын сайдын 2022.04.11 83 дугаар тушаал, ГЗБГЗЗЕГД-гын 2024.03.18 А/83 тоот тушаалаар нэмэлт дансанд төвлөрдөг хяналтын орлогоос зарцуулах эдийн засгийн зардлын ангиллыг зааж өгсөн боловч 660.0 мянга төгрөгийн санхүүгийн программын төлбөр төлсөн нь тус тушаалын хавсралттай нийцэхгүй байна.	1	660.0					1	660.0					
Дүн	1	660.0					1	660.0					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.	1	3,350,526.2			1	3,350,526.2
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						